



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/61

Баянтал сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолын 8-р хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших хүсэлт гаргасан Баянтал сумын Засаг даргын Тамгын газарт хавсралтанд заагдсан байршил, хэмжээ, зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмшилдээ авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

3. Баянтал сумын Засаг даргын Тамгын газарт эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудсыг өгч, газар эзэмших гэрээ болон гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (Б.Батчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



Баянтал сумын Засаг даргын 2025 оны
06 сарын 04-ны өдрийн 461 дугаар
захирамжийн хавсралт

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын
эзэмшилд олгож буй газрын байршил, хэмжээ, зориулалт

Д/д	Нэр	Регистрийн дугаар	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газар эзэмших хугацаа /жил/	Газрын хэмжээ /м²/	Газрын зориулалт	Газрын байршил, нэр
1	Баянтал сумын Засаг даргын Тамгын газар	9018522	4261578	15	20004	Олон улсын, улсын, орон нутгийн чанартай автозамын тээврийн хэрэгслийн түр зогсоолын талбайн	Сүлд 13- р гудамжны баруун талд





ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/62

Баянтал сум

2026 оны Газар зохион байгуулалтын
төлөвлөгөө боловсруулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.13, 59.1.23, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, 25 дугаар зүйлийн 25.4, Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.24.2 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2026 оны тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ш.Шинэбаяр

(Засаг даргыг Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Б.Батчимэг

(Газрын даамал)

Гишүүд:

Э.Түмэн-Эрдэнэ

(Лүн багийн Засаг дарга)

Т.Ган-Эрдэнэ

(Их уул багийн Засаг дарга)

(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

(Бэлчээр, газар тариалан хариуцсан

мэргэжилтэн)

2.Ажлын хэсгийн ажиллах ажил үүргийн хуваарийг нэгдүгээр, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөний төслийг холбогдох журмын дагуу боловсруулж, 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Ш.Шинэбаярт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



تعود رعيته من سجنه في السجناء
سنة مستمرة في كل سنة

وہیں سے (میں نے) فرمایا

6/9/44
مستقر

پیش و پیش (نم) پیش

[illegible]

مہتمم مسٹر ویسٹمنسٹر سکول امر

بخرین و دختتمینو مصلی

[illegible][illegible]

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

۲. بخش‌های

(فرضه مستحقه در مسینه) قدر ششصد و شصت و دو)

و، و ق م خ د ن

نیکم و اکرم یمن مصطفیٰ:

(فُتِحَ لَهُمْ مَسْجِدٌ)

1. مطالعہ - ۱۹۶۱

نمبر دوم:

(پہلی و سہرے کے درمیان صبح)

ۛ . عُسَا - یَہُئ

(نقد و استقراء و نقد و استقراء)

(والْحَسَنُ وَالْحَكِيمُ بِمَا يَخْتَارُ لَكَ بِمِصْرَ مِصْرَ وَالْحَسَنُ)

(ویکٹر، ٹیمن، سکاٹسٹا، سنڈن، سرسر، پیرایوس)

[illegible][illegible][illegible]

خبریں سنیں



Сумын Засаг даргын 2025 оны ...
 06 дугаар сарын 04-ны өдрийн 1/64 дугаар
 захирамжийн 1. дүгээр хавсралт

СУМЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
 БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Д/д	Албан тушаал	Ажил үүргийн хуваарь
1	Засаг даргын тамгын газрын дарга	Ажлын хэсгийг хуралдуулах, ажлын төлөвлөгөө, ажил үүргийн хуваарийг ногдуулах, шуурхай удирдлагаар хангах, ажлын хэсгийн хамт Засаг даргын зөвлөл, ИТХ-д оруулах
2	Нарийн бичиг, Газрын даамал	Бэлтгэл аргачлалын дагуу хангах, аргачлалыг танилцуулах семинар зохион байгуулах, ажил үүргийн хуваарь гаргаж ажлын хэсгийн ахлагчид танилцуулах
		Иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, Хоршоо ААН-ийн гэрээ (лицен)-ээр эзэмшил, ашиглалтанд байгаа газрын хил заагийг газрын зурагт оруулах
		Санал авах ажлыг зохион байгуулах, ажлын хэсгийн гишүүдэд семинар өгөх
		Саналыг эрэмбэлэн шалгаруулж нэгтгэн төлөвлөгөөнд тусгах, эзэмших, ашиглах, нөхөн сэргээх, хөрөнгө оруулалт хийх газрын байршил, хэмжээг газар дээр нь очиж GPS багажаар хэмжих, зурагт буулгах, ажлын хэсгийн гишүүдийн гүйцэтгэсэн санал, төлөвлөгөөг нэгтгэн газар зохион байгуулалтын зураг төслийн хэлбэрт оруулан зохих програм хангамжаар боловсруулан ажлын хэсгээр батлуулах
3	Багийн Засаг дарга	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын нөхөрлөл, бүлгүүдээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах санал гаргуулах
		Багийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, малчдын саналыг багийн түвшинд нэгтгэх, багийн зүгээс нэмж оруулах саналыг тусгах, багийн ИНХ-аар хэлэлцүүлж санал авах
		Баг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн саналыг сумын газрын даамалд хүргүүлэх
7	Бэлчээр газар тариалын хариуцсан мэргэжилтэн	Бэлчээр ашиглалтын хуваарь, амрааж өнжөөх бэлчээрийн хуваарийг тогтоох
		Ган зудын үед өөр аймаг, сумын нутагт отор нүүдэл хийх асуудлыг судалж, зураглал схемийг гаргах
		Бэлчээрийн хортон, мэрэгчидтэй тэмцэх газрын

		төлөвлөгөөнд тусгах
		Бэлчээр хадланг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, ургац нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоо судалгааг гаргах
		Ган зуд, байгалийн гамшгийн давтамжийг иргэдэд сурталчлах, дасан зохицох менежментэд сургах, отор нүүдлийг хэрхэн зохион байгуулах саналыг боловсруулах
		Бэлчээрийн нөөц, даацтай уялдуулан малын үүлдэр угсааг сайжруулах, мал эрүүлжүүлэх, 1 малаас авах ашиг шимийг тооцох чиглэлийн үйл ажиллагааг төлөвлөн төлөвлөгөөнд тусгуулах

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Ажлын хэсгийг хуралдуулах, төлөвлөгөө боловсруулах	2025.06.20	Засаг даргын тамгын газрын дарга
2	Бэлтгэл ажлыг аргачлалын дагуу газар зохион байгуулалтын ажилд шаардагдах төлөвлөлт тус бүрээр зураг, техник хэрэгслийг бэлтгэх	2025.06.20	Нарийн бичиг
3	Бэлтгэл ажлын аргачлалыг танилцуулах семинарыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд зохион байгуулах	2025.06.20	Газрын даамал
4	Санал авах ажлыг зохион байгуулах, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд зөвлөмж өгөх	2025.06.25	Газрын даамал
5	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, бүлгүүдээс веб системээр болон уламжлалт аргаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг авах	2025.09.15	Багийн Засаг Газрын даамал
6	Багийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, малчдын саналыг тусгах ИНХ-аар хэлэлцүүлж санал авах	2025.09.15	Багийн Засаг дарга нар
7	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, малчдын саналыг сумын Газрын даамалд нэгтгэн хүргүүлэх	2025.09.20	Багийн Засаг дарга нар
8	Ирүүлсэн саналыг эрэмбэлэн шалгаруулж нэгтгэх	2025.09.25	Ажлын хэсэг
9	Шинээр гаргах, засварлах, эзэмшүүлэх, худаг уст цэгийн талаар малчид, малчдын нөхөрлөл, бүлгийн саналыг үндэслэн байршлыг тогтоож, тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулах	2025.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
10	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр хийгдэх ажлын байгаль орчны үнэлгээ гаргах	2025.09.30	Хөгжлийн бодлогын тасгийн дарга

11	Бэлчээр ашиглалтын улирлын хуваарь, амрааж өнжөөх бэлчээрийн хуваарийг тогтоох	2025.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
12	Бэлчээрийн хортон, мэрэгчидтэй тэмцэх газрын төлөвлөгөөнд тусгах	2025.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
13	Бэлчээр хадланг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, ургац нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоо судалгааг гаргах	2025.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
14	Ашиглалтгүй бэлчээрийн судалгааг гаргаж, ашиглах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх	2025.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
15	Эрчимжсэн мал аж ахуйн бүс нутгийн ашиглалт, хамгаалалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх	2025.09.30	Газрын даамал
16	Төлөвлөгөөнд тусгагдаагүй төлөвлөлтийн талаархи саналын хувилбаруудыг гаргаж, ажлын хэсгийн хуралдаанаар оруулж батлуулан Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар танилцуулах	2025.10.05	Газрын даамал
17	Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор нэгдсэн цахим системд байршуулж, аймгийн ГХБХБГазарт хүргүүлэх	2025.10.10	Газрын даамал
18	Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийн хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх	2025.12.10	Газрын даамал

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/63

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Талын Илч "ОНӨААТҮГ" (2005166) нь Баянтал сумын Лүн багт Их уул-2 2011 тоот хаягт байрлах 4203000261 нэгж талбар бүхий 5350м² уурын зуухны зориулалттай газрынхаа газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 40 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Талын Илч "ОНӨААТҮГ"-ын захирал (Б.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй Талын Илч "ОНӨААТҮГ" захирал (Б.Энхтүвшин)-тай эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Б.Батчимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 74 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/64

Баянтал сум

Хяналтын камер тавих ажилд хөрөнгө зарцуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Сумын 2025 оны төсөв батлах" тухай 03 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Суманд шинээр хяналтын камер тавих" ажлыг худалдан авахад 19,830,000 (арван есөн сая найман зуун гучин) төгрөгийг хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг 2025 оны сумын төсөвт тусгагдсаны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас санхүүжүүлэхийг санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д даалгасугай

3. Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болсугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/65

Баянтал сум

Төрийн албан хаагчдын тоног төхөөрөмжийг
сайжруулах, тавилга эд хогшил худалдан авах
ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Сумын 2025 оны төсөв батлах" тухай 03 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Төрийн албан хаагчдын тоног төхөөрөмж сайжруулах, тавилга эд хогшил шинэчлэх" барааг худалдан авахад 61,970,000 (жаран нэгэн сая есөн зуун далан мянган) төгрөгийг хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг 2025 оны сумын төсөвт тусгагдсаны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас санхүүжүүлэхийг санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д даалгасугай.

3. Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болсугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/66

Баянтал сум

Эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023-2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 16,000,000 (арван зургаан сая) төгрөгийн ажилд "сумын 2024 оны ОНХС-гийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн түүвэрчилсэн аудитаар илэрсэн 59/A0871141, ГСА-2025/007/НА-СТА-ОНТС-ийн "Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод бутны суулгац авах" ажлын моднуудыг бараа материалын зардал, бусад эд хөрөнгийг шууд зардалд тусгаж зөрчлийн арилгаж үнэ бүхий эд хөрөнгүүдийг хавсралтад зааснаар байгууллагынхаа эд хөрөнгийн бүртгэлд авахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр)-д зөвшөөрсүгэй.

2.Эд хөрөнгийг 2025 оны тайланд тусгаж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад холбогдох хууль, дүрэм журмын дагуу хяналт тавьж ажиллахыг байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 4/67

Баянтал сум

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга
хэмжээнээс орж ирсэн орлогыг
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам" -ын 2 дугаар тогтоолын 3 дугаар зүйл 3.1, 3.4, 3.5, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулах төсвийн задаргааг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний орлого 30,000,000.00 (Гучин сая) төгрөгийг Байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

3.Байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Тамгын дарга (Ш.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА

Сумын Засаг даргын 2025 оны 06
дугаар сарын 20-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт



Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний
зарцуулах төсвийн задарга

/Мянган төгрөгөөр/

№	Төсөл арга хэмжээний нэр	Зарцуулах төсөв
1. Хөтөлбөр төсөл, арга хэмжээ		
1.1	"Тэрбум мод үндэсний хөдөлгөөний" хүрээнд сумын хэмжээнд нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд	8,000.0
1.2	Байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг сурталчлах болон тогтвортой хөгжлийн боловсрол олгох, иргэдийн байгаль хамгаалах мэдлэг хандлагыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах	2,000.0
1.3	Иргэн, аж ахуйн нэгж байгуулагыг байгаль орчин, ан амьтан ээлтэй идэвхитэн байгаль хамгаалах шалгаруулан мөнгөн урамшуулал олгох	2,000.0
1.4	Улирал бүр идэвхтэйн байгаль хамгаалагч цагдаагийн бүрэлдэхүүнтэйгээр эрүүл тойруул хийх	1,500.0
1.5	Төмөр замын торон хашааны хамгаалалтыг хамтран сайжруулах, шороон далан босгох ажлыг хийж гүйцэтгэх	2,000.0
1.6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажил	14,500.0
Нийт дүн		30,000.0



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 4/68

Баянтал сум

Баяр наадам зохион байгуулах ажлын
хэсгийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.3 Үндэсний их наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.9, 17, Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/259 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улсын 819 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 104 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Баяр наадмын үйл ажиллагааг өндөр түвшинд зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг зохион байгуулах хорооны дарга (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА

Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын
20-ны өдрийн 118 дугаар захирамжийн
дүгээр хавсралт

СУМЫН БАЯР НААДМЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Төв комиссын дарга:

Гишүүд

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч)

Э.Түмэн-Эрдэнэ (Лүн Багийн засаг дарга)

Т.Ган-Эрдэнэ (Их -Уул Багийн засаг дарга)

Г.Анхбаяр (Хурд боржигон уяачдын

холбооны тэргүүлэгч)

Д.Мөнх-Эрдэнэ (Бөхийн холбооны тэргүүн)

С.Доржсүрэн(Шагайн холбооны тэргүүн)

Б.Бямбадорж (Цагдаагийн хэсгийн

төлөөлөгч)

Л.Лхагвасүрэн(Ахмадын хорооны дарга)

Х.Энхжаргал (Соёлын төвийн эрхлэгч)

Д.Цэрэнням (Ерөнхий боловсролын

сургуулийн захирал)

Б.Золзаяа (Цэцэрлэгийн эрхлэгчийн

үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Баярбаатар(Эрүүл мэндийн дарга)

Л.Отгонпүрэв (Санхүү албаны дарга)

Б.Энхтүвшин (Талын Илч ОНӨААТҮГ-ын

дарга)

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, худалдан

авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Ц.Булган(Хууль эрх зүй, дотоод хариуцсан

мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ш.Шинэбаяр(Тамгын газрын дарга)



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/69

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1,23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2025 оны 06 дугаар ээлжийн хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн арга хэмжээнүүдэд 6,988,650 (зургаан сая есөн зуун наян найман мянга зургаан зуун тавь) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 6,988,650 (зургаан сая есөн зуун наян найман мянга зургаан зуун тавь)төгрөгийг Сумын Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э БАТТУЛГА

4212500113

Засаг даргын 2025 оны 6-р сарын
20-өдрийн 11/69 дугаар захирамжийн
хавсралт



№	Арга хэмжээ	Тоо ширхэг	Төсөв	Нийт
1	Оюутны сургалтын тэтгэлэг олгох/Төрийн албан хаагчдад/	4	1,000,000	4,000,000
2	ЕБС-ийн үй ажиллагааг дэмжих /Сүү хөтөлбөр/	1	2,500,000	2,500,000
3	Малын тоо толгойн хагас жилийн тооллогыг зохион байгуулах зардал	1	488,650	488,650
Нийт			6,988,650	



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/70

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1,23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2025 оны 07 дугаар ээлжийн хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн арга хэмжээнүүдэд 1,276,000 (нэг сая хоёр зуун далан зургаа мянган) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 1,276,000 (нэг сая хоёр зуун далан зургаа мянган) төгрөгийг Сумын Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

4212500061

Засаг даргын 2025 оны 26-р сарын
2-д өдрийн 13-дугаар захирамжийн
хавсралт



№	Арга хэмжээ	Тоо ширхэг	Төсөв	Нийт
1	Шүүхэд үнэлгээний мөнгө шилжүүлэх	1	1,000,000	1,000,000
2	Сумын цагдаагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх/шатахуун/	100	2760	276,000
Нийт			1,276,000	



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/71

Баянтал сум

Өвс тэжээл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх журам"-ын 4.13 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын зөвлөлийн 2025 оны 02-р сарын 19-ний өдрийн хуралдаанаар сумын морьт харвааны дугуйлангийн морьдод сумын өвсний нөөцөөс 100 боодол өвс, 50 шуудай овьёос, 50 шуудай буудай олгох шийдвэрийн дагуу Морьт харвааны "Зэв" клубын багш (Б.Аягаа)-д буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг сумын өвсний нөөцөөс олгохыг Засаг даргын Тамгын газрын аж ахуйн нярав (Н.Сарантуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА

4212500214



تعداد ایشان را در این کتاب
در این کتاب در این کتاب

செயல்பாடு

وہابی

۵۰۰۰ مسم و ۷۵ مسم (۱۰۰۰ مسم) ۳۰۰۰ مسم

يوسرو مكدنر هينسو ميسن

[illegible]

0.

[illegible]

۴. وہمومینز

خبر رسد مکتوباً



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/72

Баянтал сум

Эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны хагас жилийн байдлаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 9,500,000 (есөн сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий эд хөрөнгүүдийг 1 дүгээр хавсралтад зааснаар байгууллагынхаа эд хөрөнгийн бүртгэлд авахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр)-д, 19,910,000 (арван есөн сая есөн зуун арван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий эд хөрөнгийг 2 дугаар хавсралтад зааснаар байгууллагынхаа эд хөрөнгийн бүртгэлд авахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Д.Цэрэнням)-д, 59,835,000 (тавин есөн сая найман зуун гучин таван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий эд хөрөнгийг 3 дугаар хавсралтад зааснаар байгууллагынхаа эд хөрөнгийн бүртгэлд авахыг 4-р Цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Золзаяа)-д, 16,017,000 (арван зургаан сая арван долоо мянган) төгрөгийн балансын үнэ бүхий эд хөрөнгийг 4 дүгээр хавсралтад зааснаар байгууллагынхаа эд хөрөнгийн бүртгэлд авахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Баярбаатар)-д нарт зөвшөөрсүгэй.

2.Эд хөрөнгийг 2025 оны тайланд тусгаж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад холбогдох хууль, дүрэм журмын дагуу хяналт тавьж ажиллахыг байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/73

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт " Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7, 4.9 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боржигон овогтой Сампилнорвын Занданбал нь (HE66081179) Баянтал сумын 1 дүгээр багт Хүн эмнэлгийн хойд талд байрлах гэр орон сууцны хашааны газрын зориулалттай 288м2 газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул Харуул овогтой Банзрагчын Батсайхан (HE81011870)-д шинэ хаягаар Их уул-2 200 тоотод байрлах 288м2 газрыг гэр орон сууцны хашааны газрын зориулалтгаар анх авсан этгээдийн үлдсэн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу эзэмшилдээ авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг иргэн (Б.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэн, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Б.Батчимэг)-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2011 оны А/31 дугаар захирамжыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/74

Баянтал сум

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх журам"-ын 4.13 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн "Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын тоног төхөөрөмж" барааг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Э.Түмэн-Эрдэнэ (Лүн багийн Засаг дарга)

Гишүүн:

Н.Баярмаа (ИТХ-ын төлөөлөгч)

Б.Баярбаатар (Эрүүл мэндийн төвийн дарга)

Б.Энхтөр (Эрүүл мэндийн төвийн нярав)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, худалдан
авах ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичиг, гэрээнд заасны дагуу ажлын тоо хэмжээг тулган үзэж, чанартай гүйцэтгүүлж, хүлээн авахыг ажлын хэсгийн комиссын гишүүдэд даалгасугай.

3. "Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын тоног төхөөрөмж" барааг комиссын зөвлөмжид дүгнэлтийг үндэслэн, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/75

Баянтал сум

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх журам"-ын 4.13, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5, Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/257 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн "3х3 сагсан бөмбөгийн талбай шинээр хийх" ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

комиссын дарга:

Гишүүд:

Э.Эрхэмбаатар (Сумын Засаг даргын орлогч)

Б.Дэлгэрдалай (Аймгийн ГХБХБГ-ын
Барилгын асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн)

Т.Эрдэнэбаяр (Аймгийн ГХБХБГ-ын
барилгын техник хяналтын
Улсын байцаагч)

Н.Мөнгөнцэцэг (сумын ЗДТГ-ын архив, бичиг
хэргийн эрхлэгч)

Н.Сарантуяа (Баянтал сумын ЗДТГ-ын аж
ахуйн нярав)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Сумын ЗДТГ-ын
Нийгмийн бодлого, худалдан авах
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичиг, гэрээнд заасны дагуу ажлын тоо хэмжээг тулган үзэж, чанартай гүйцэтгүүлж, хүлээн авахыг ажлын хэсгийн комиссын гишүүдэд даалгасугай.

3. "3х3 сагсан бөмбөгийн талбай шинээр хийх" ажлыг комиссын зөвлөмжид дүгнэлтийг үндэслэн, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр) дүүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Э.БАТТУЛГА



